



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Г “Мах” бондын зарим хэсгийг
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жаст агро” ХХК-иас гаргасан 12 сарын хугацаатай, жилийн 16.2 хувийн хүүтэй, нэг бүр нь 10,000 /арван мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,000,000 /гурван сая/ ширхэг “Мах” бондын арилжигдаагүй үлдэгдэл болох 2,560,046 /хоёр сая таван зуун жаран мянга дөчин зургаа/ ширхэг бондыг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, төвлөрсөн хадгаламжаас хасахыг “ҮЦТТТХТ” ХХК/Д.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Арилжигдсан бондын /10,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 439,954 ширхэг/ үндсэн болон хүүгийн төлбөрийн барьцаанд нийт **6,709,274,300** /зургаан тэрбум долоон зуун есөн сая хоёр зуун далан дөрвөн мянга гурван зуу/ төгрөгийн үнэлгээ бүхий “Жаст агро” ХХК-ийн “Баян-Өлгий мах маркет”, “Хөвсгөл мах маркет” үйлдвэрүүдийн үл хөдлөх хөрөнгүүдийг үлдээхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, “Жаст агро” ХХК/Т.Содномдаржаа/, “Би Ди Сек” ХК/Д.Даянбилгүүн/-д тус тус даалгасугай.

3. Бондын орлогоос татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үндсэн болон хүүгийн төлбөрт холбогдох журмын дагуу үргэлжлүүлэн хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, “ҮЦТТТХТ” ХХК/Д.Гандулам/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН